



# СОЁМБО

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨВ ЗҮТГЭЭ!

№92  
(92)

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.07.09

## ҮЙЛ ЯВДАЛ

### БАТЛАН ХАМГААЛАХЫН ДЭД САЙД ОЛИМПОД ОРОЛЦОХ ТАМИРЧДАД АМЖИЛТ ХҮСЛЭЭ



Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай эх орноо төлөөлөн "Токио-2020" олимпод оролцох баг тамирчдад амжилт хүсэж гарын бэлэг дамжууллаа. Энэ сарын 23-нд эхлэх "Токио-2020" олимпын наадамд Монголын тамирчид байт харваа, буудлага, бокс, жудо, чөлөөт бөх, 3x3 сагсан бөмбөг, усанд сэлэлт, одон бөмбөг, хөнгөн атлетик, хүндийн өргөлт гэсэн спортын 10 төрөлд 43 эрх аваад байгаа юм. Эндээс БХЯ-ны харьяа "Алдар" спорт хорооноос спортын 7 төрлөөр 12 тамирчин эрхээ баталгаажуулаад байна. Тухайлбал, буудлагын төрлөөр Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, гавьяат тамирчин, дэд хурандаа О.Гүндэгмаа, ОУХМ, ахлагч Э.Даваахүү, байт харвааны төрлөөр ОУХМ, ахлагч Б.Отгонболд, марафонны төрөлд ОУХМ, дэд ахлагч Б.Мөнхзаяа, ОУХМ, ахлах ахлагч Ц.Бямбажав, боксын төрөлд ОУХМ, ахлах ахлагч Б.Чинзориг, паратаеквондоогоор ОУХМ Х.Энхтуяа, ОУХМ Г.Болор-Эрдэнэ, хүндийн өргөлтөөр МУГТ ахлах дэслэгч М.Анхцэцэг, жудо бөхийн төрлөөр ОУХМ, дэслэгч Г.Алтанбагана, МУГТ, дэслэгч Ө.Дүүрэнбаяр, ахлагч Б.Ганхайч нар өрсөлдөх юм.

Батлан хамгаалахын дэд сайд энэ үеэр "Монгол Улсын нэр хүндийг гөргөсөн олон төрлийн уралдаан тэмцээнд Зэвсэгт хүчнээр овоглосон манай тамирчид хэзээд амжилттай оролцож байсан. Энэ удаад ч гэсэн та бүхэн зорьсондоо хүрч амжилтаа бататгана гэдэгт итгэл төгс байна" гэдгээ дасгалжуулагчдаар нь дамжуулан уламжилсны зэрэгцээ тамирчдад зориулсан төрөл бүрийн амин дэм, витамин, ураг зэргийг гардуулан өгсөн юм.

## ЦАХИМ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Энэ сарын 8-ны өдөр ЗХЖШ-ын АУГ-ын дарга, бригадын генерал С.Дашзэвэг Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын захирагч нартай цахим хурал зохион байгуулсан ба хурлын эхэнд Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын захирагч нарын товч илтгэлийг сонссон юм. Хурлын үеэр коронавирусийн халдварт өвчний улмаас Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр Ардын хувьсгалын 100 жилийн ойн баярыг тэмдэглэх асуудлыг ирэх жилийг хүртэл хойшлуулсан хэдий ч "Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль"-д заасны дагуу 7 дугаар сарын 10-19-ний өдрийг хүртэл хугацаанд олон хоногоор амрах болсонтой холбогдуулан ЗХЖШ-ын даргаас өгсөн чиглэлийн дагуу дараах үүргийг хүргүүлжээ. Үүнд:

1. Улс орны хэмжээнд тархаж буй цар тахлын нөхцөл байдлаар уялдуулан коронавирусийн халдварт өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг хэрэгжүүлэх, амралтын өдрүүдийг зөвхөн гэр бүлийн хүрээнд зөв зохиостой, үр дүнтэй өнгөрүүлэх;

2. Баяр, амралтын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай ЗХЖШ-ын даргын 2021 оны А/338 дугаар тушаал гарч Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, байгууллагуудад хүргүүлсэн ба энэхүү тушаалын хэрэгжилтийг бүрэн хангах, тушаалыг заалт бүрээр нь цэргийн алба хаагч, ажилтнуудад нэг бүрчлэн танилцуулж, гарын үсэг зуруулж баталгаажуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих, амралтын өдрүүдийг өнгөрүүлсэн дүнг гаргаж, 19-ний өглөө албан бичгээр болон биечлэн илтгэх;

3. Амралтын өдрүүдэд зайлшгүй шалтгаанаар хөдөө, орон нутаг явах болсон албан хаагч нь Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын захирагчид хувийн өргөдөл, хүсэлтийг гаргаж, албан ёсны зөвшөөрөл авах, ингэхдээ нэгтгэл, анги, байгууллагын жижүүрт заавал бүртгүүлж хэвших;

4. Баяр, амралтын өдрүүдээр Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын

эргүүл, жижүүрт туйлын хариуцлагатай, тэргүүний офицер, ахлагч нарыг сонгон томилж, тэдэнтэй сурган зааварлах хичээлийг явуулах, байнгын удирдлагаар хангаж, үүрэг гүйцэтгэлтэд нь хяналт тавьж, үр дүнг тооцох;

5. Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад цэргийн цагдаагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэлийг эрчимжүүлэх, хоёроос доошгүй цэргийн алба хаагчийн бүрэлдэхүүнтэй эргүүлийг гурван ээлжээр нэгтгэл, анги, байгууллагын байрлал, албан тушаалын байр, эрсдэл бүхий объект, голын эргийн дагуу томилон үүрэг гүйцэтгүүлэх, энэ үед "Цэргийн цагдаагийн ажиллагааны журам"-ыг ягштал мөрдөх;

6. Бие бүрэлдэхүүний сонор сэрэмжийг өндөржүүлэн, дотоодын хяналт шалгалтыг чангатгах, амралтын өдрүүдэд зайлшгүй гарах тээврийн хэрэгслүүдийн техникийн бэлэн байдлыг шалгаж, Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албанд бүртгүүлснээр үйлчилгээний зөвшөөрөл авах;

7. Цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын ахуй хангалт, эрүүл мэндэд онцгой анхаарч, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулсны үндсэн дээр соёл хүмүүжлийн ажлыг зохион байгуулж, дайчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл бололцоог хангаж ажиллах. Ингэхдээ түр цагийн чөлөө олгохыг бүр мөсөн хориглож, шалган нэвтрүүлэх байранд ар гэрийнхний уулзалтыг зохион байгуулахгүйгээр халдвар хамгааллын дэглэмийг баримтлах;

8. Баяр, амралтын өдрүүдэд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, нэн ялангуяа улсын

хэмжээнд гол, мөрний усны төвшин нь үерийн хэмжээнээс дээшилсэнтэй холбоотойгоор гол, усанд орохгүй байж, үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

9. Нэгтгэл, анги, байгууллагуудад "Галын аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө"-г тодотгож, орон тооны бус томилгоот бүрэлдэхүүнтэй сурган зааварлах хичээлийг явуулан, галын эргүүлийг тогтмол ажиллуулах, гал түймрээс урьдчилан сэргийлэх;

10. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн ангиуд нисдэг тэрэг болон нисдэг тэрэгний багийн бүрэлдэхүүний томилгоог тодотгож, эрүүл мэндийн байдалд нь хяналт тавих, үүрэг гүйцэтгэхэд бэлэн байлгах;

11. Тусгай үүрэг гүйцэтгэх томилгоот бүрэлдэхүүнийг тодотгож, хүн, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах, ялангуяа хөдөө, орон нутагт байрлаж байгаа нэгтгэл, анги, салбарууд энэ чиглэлд онцгой анхаарах;

12. Нийт алба хаагчдад гэр бүлийн хүрээнд зөв боловсон, үр ашигтай, ая тухтай амрах, гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, архиан согтуурахтай холбоотой ямар нэгэн асуудал гаргахгүй байхыг хатуу анхааруулж, хяналт тавих зэрэг үндсэн асуудлуудаар үүрэг, даалгаврыг өглөө.

Цахим хурлын төгсгөлд ЗХЖШ-ын дарга болон даргын зөвлөлийн гишүүдээс нийт генерал, офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч, ажилтан албан хаагчид, хилийн чанадад үүрэг гүйцэтгэж байгаа энхийг сахиулагчдад Тулгар төрийн 2230, Их Монгол Улс байгуулагдсаны 815, Ардын хувьсгалын 100 жилийн ойн баярын мэндчилгээг өргөн дэвшүүлснийг уламжилсан юм.

## ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 22	☁️ 7
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 33	☁️ 23
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 37	☁️ 23

## ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.849.00	2.852.00
EUR 🇪🇺	3.380.00	3.400.00
CNY 🇨🇳	440.50	441.50
RUB 🇷🇺	37.80	39.40
JPY 🇯🇵	25.46	25.94
KRW 🇰🇷	2.42	2.55

## ЗУРХАЙ

Билгийн тооллын: 30,  
2021.07.09  
/БААСАН ГАРАГ/

### ЗУНЫ ДУНД ХӨХ МОРЬ САРЫН ДОЛООН УЛААН ШАР МОРЬ ӨДӨР

**Үс засуулбал:**  
Эрлэг лугаа учирна  
Наран ургах, шингэх:  
05.03-20:52

**Барилдлага:**  
Идэр  
Шүтэн барилдлага:  
Хуран үйлдэхүй  
Суудал:  
Мод

Билгийн тооллын: 30,  
Хэрцгий охин одтой, шар морь өдөр. Тухайн өдөр нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, гаргагийг тахиу, тангараг тавих, гэр, байшингийн суурь тавихад сайн.

Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, улаа гаргах, хиншүү хяравс гаргахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогосод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгээх буюу засуулахад тохиромжгүй.

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 131.962 +1510	ЭДГЭРСЭН 93,840 +1541	НАС БАРСАН 655 +9
-----------------------------------	--------------------------	----------------------

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 3618 +61	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 325 +17	ЭДГЭРСЭН 3230 +31
-----------------------------	--------------------------------	----------------------

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 185,078,882
Эдгэрсэн Нийт: 170,077,520
Нас барсан Нийт: 4,001,791



ҮЙЛ ЯВДАЛ

# “ЦЭРГИЙН ХОЛБООНЫ ТҮҮХИЙН ТОЙМ” НОМЫН НЭЭЛТ БОЛОВ



генерал Ч.Сосорбарам юм. Зэвсэгт хүчний холбоо, цэргийн удирдлагын автоматжуулсан систем, хэрэгслийн бэлэн байдлыг хангах, орчин үеийн тоон технологиор шинэчлэх, мэдээллийн сан, программ хангамжуудыг шинээр зохион ашиглах, холбоочдын үүрэг гүйцэтгэх чадавх, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, холбоо, мэдээллийн техник хэрэгсэлд хийгдэх засвар, техникийн үйлчилгээг технологийн дагуу хийх, Зэвсэгт хүчинд төрийн болон цэргийн нууцыг чанд хадгалах, хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, Зэвсэгт хүчний анги, салбарууд, гадаадад үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн багуудтай мэдээллийн харилцааг тасралтгүй хэрхэн зохион байгуулж байгаа зэргийг энэхүү бүтээлд тусгажээ.

Монгол Улсад орчин цагийн Цэргийн холбоо үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан гаргасан “Цэргийн холбооны түүхийн тойм” номын нээлт өчигдөр боллоо. Нээлтийн арга хэмжээнд ЗХЖШ-ын ХМТХ-ийн дарга,

хурандаа М.Золзаяа, доктор, профессор, бэлтгэл бригадын генерал Ч.Сосорбарам, бэлтгэл бригадын генерал П.Пүрэвбазар болон бусад зочид төлөөлөгчид байлцлаа. Цэргийн холбооны 2000-2021 оны түүхийг багтаасан тус бүтээлийн зохиогч нь доктор, профессор, бэлтгэл бригадын

Зэвсэгт хүчний 336 дугаар анги

## ХОЛБООЧИН АХЛАГЧ “БИДНИЙ БАХАРХАЛ”

Монгол Улсын Зэвсэгт хүчинд Холбооны цэрэг үүсэж хөгжсөний түүхт-100 жилийн ойг тохиолдуулан “Ахлагчийн зөвлөл”-ийн хамт олноос холбооны мэргэжлийн ахлагч нарын гүйцэтгэж буй үүрэг, үйл ажиллагааг сурталчлан таниулах, тэдний манлайллыг залуу хойч үеийнхэндээ алдаршуулах зорилгоор Холбооны албанд “Бидний бахархал” хэмээх хүндэтгэлийн буланг шинээр тохижуулан хүлээлгэн өглөө. Энэхүү хүндэтгэлийн буланг тохижуулж өгсөн ангийн “Ахлагчийн зөвлөл”-ийн хамт олондоо ажил, хөдөлмөрийн өрнүүн их амжилтыг хүсэн ерөөе.



## ИХ ГОВИЙН ГАРИНЗОНЫ ХОЛБООЧДЫН ЯРУУ АЛДАР БАДАРТУГАЙ



Орчин цагийн Зэвсэгт хүчинд Цэргийн холбоо үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн баярыг 2021 оны 7 дугаар сарын 8-ны өдөр ёслол төгөлдөр тэмдэглэсэн юм. Уг ёслолын хүндэтгэлийн ажиллагааг нээж Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн захирагч, хурандаа А.Болдбаатар мэндчилгээ дэвшүүлэн баяр хүргэж Холбооны алба, “Улз” зангилааны хамт олонд “талархал” үнэ бүхий зүйлийг гардууллаа. Мөн энэ үеэр чөлөөнд байгаа

ахмад холбоочдоо хүндэтгэл үзүүлсэн юм. Холбооны албаны бие бүрэлдэхүүн болон ахмад холбоочдыг Цэргийн холбоо үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн “Дурсгалын медаль”-аар, ажилтан Ө.Будыг “Хөдөлмөрийн хүндэт медаль”, Зэвсэгт хүчний 100 жилийн ойн медалиар, Цахим сүлжээний техникч, ахлагч Б.Батзолбоог Монголын залуучуудын холбооны “Монгол тандаа зүтгэе” медалиар тус тус шагнаж урамшуулсан юм.

Арга хэмжээний төгсгөлд бэлтгэл ахлах ахлагч Б.Бат-Эрдэнэ, ахлах ахлагч С.Урангуа нар холбооны албаныхаа хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Холбооны сургалтын танхимын тохижилтод 7 ширхэг иж бүрэн сандал, ширээ хийх зардал болох 570,000 төгрөгийг, ахмад холбоочин бэлтгэл хошууч Н.Лхагвадорж, ахлагч У.Бумдарь нар “Улз” зангилаанд 32 инчийн LCD зурагт, станцын хамт гардуулан өглөө.

Дэслэгч Ч.БОДЫГЭРЭЛ

# ХОЁРДУГААР ШАТНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХУРАЛ БОЛОВ



Монгол Улс, ОХУ-ын хамтарсан “Сэлэнгэ-2021” байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийн хоёрдугаар шатны төлөвлөлтийн хурлыг энэ сарын 1-5-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Төлөвлөлтийн хуралд Монгол Улсыг төлөөлж Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаяр, ХЗЦ-ийн командлалын Цэргийн сургалт, соёл хүмүүжлийн хэлтсийн сургалтын ахлах офицер, хурандаа Т.Тогмиддүүмий, ХЗЦ-ийн Артиллерийн дарга, дэд хурандаа С.Ганбаяр, ОХУ-ыг төлөөлж Дорнод цэргийн тойргийн 36 дугаар армийн штабын дарга, хошууч генерал И.Б.Тимофеев,

Байлдааны бэлтгэлийн тасгийн дарга, хурандаа Д.В.Прокофьев, Дорнод цэргийн тойргийн Тээврийн хангалтын удирдлагын газрын даргын орлогч А.Г.Сапов болон албаны бусад хүмүүс байлцлаа.

Хурлаар сургууль явагдах районд ОХУ-ын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид төмөр замаар тээвэрлэгдэн ирэх, хоёр орны цэргийн алба хаагчдын байрлах байр, цэргийн техник хадгалах хээрийн тавиулан, зэвсэг, галт хэрэглэл хадгалах байр зэргийг хэрхэн бэлтгэх, алба хаагчид өөрсдийн орон тооны зэвсэглэл, тэдгээрийн шатахуун, тосолгооны материал, буудлагын зэвсэг ба галт хэрэгсэлтэй хэрхэн үүрэг гүйцэтгэх талаарх асуудлыг тодотгов.

Мөн ОХУ-аас оролцож байгаа бие бүрэлдэхүүнийг Монгол Улсын хилийг нэвтэрсний дараа цэргийн цувааг бүрэн бүрэлдэхүүнээр нь саадгүй тээвэрлэх асуудлыг зохицуулахаас гадна тэдний хөдөлгөөний аюулгүй байдал, мөн хээрийн лагерийн байрлалын район, тавиулангийн харуул хамгаалалтын талаар харилцан ярилцаж, тохиролцов. Түүнчлэн хамтарсан сургуулийн үеэр Төв аймгийн Зуунмод суманд Монгол Улсын Зэвсэгт хүчний 100 жилийн ойд зориулсан цэргийн ёслол, хүндэтгэлийн ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд ОХУ-аас тус хээрийн сургалтад оролцож байгаа бие бүрэлдэхүүн ч оролцох юм.

## ТАНКЧДАД БАЯР ХҮРГЭЖ, АМЖИЛТ ХҮСЭВ



Монгол Улс, ОХУ-ын хамтарсан “Сэлэнгэ-2021” байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийн

хоёрдугаар шатны төлөвлөлтийн хуралд ОХУ-ын Зэвсэгт хүчнийг төлөөлж ирсэн Дорнод цэргийн тойргийн 36 дугаар армийн

штабын дарга, хошууч генерал И.Б.Тимофеев, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаярын урилгаар “Армийн тоглолт-2021” олон улсын цэргийн наадамд Монгол Улсыг төлөөлж оролцох танкийн биатлоны баг, тамирчдын бэлтгэл, сургуулилттай танилцсан юм.

Энэ үеэр хошууч генерал И.Б.Тимофеев “Өөрийн орноо төлөөлөн энэхүү нэр хүндтэй тэмцээнд оролцож байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний алба хаагчдад амжилт хүсье. Танай цэргийн алба хаагчдын эрэмгий, баатарлаг, дайчин чанартайг мэдэж байгаа учир амжилт дагуулна гэдэгт итгэл төгс байна” хэмээн Монгол Улсын Зэвсэгт хүчний баг тамирчдад урам өгч, амжилт хүслээ.

## БИДНИЙ АМЖИЛТ



Зэвсэгт хүчний 186 дугаар анги

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын тушаалын дагуу Монгол Улсын хэмжээнд “Дасгал хөдөлгөөнөө хийцгээе” идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих сарын аяны нэгдсэн удирдамжийн дагуу Орхон аймгийн Биеийн тамир, спортын газрын санаачилсан “Эрүүл мэндийн цахим гүйлт -2021” аян амжилттай зохион байгуулагдлаа. Сарын аян нь “Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл зөв амьдралын хэв маягийг хэвшүүлэх дадал олгох, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх,

бие бялдраа чийрэгжүүлэх, биеийн дархлааг дэмжих” зорилготой бөгөөд энэхүү аян нь цахим хэлбэрээр буюу гүйлтийн “STRAVA” апплейкшнд групп үүсгэж байгаагаараа онцлог бөгөөд аянд Төрийн болон ТББ, Зэвсэгт хүчний 186 дугаар анги нэгдэн орж идэвхтэй оролцлоо. Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн тухайд А/156 дугаар тушаалын хүрээнд ангийн Биеийн тамирын албаны санаачилгаар унадаг дугуйтай офицер, ахлагч, ажиллан алба хаагчдыг дэмжин ангийн байрлалд 150 орчим унадаг дугуй байрлуулах зогсоолыг шинээр хийж ашиглалтад оруулсан. Мөн

биеийн тамир, спортын офицер, ахлах ахлагч Э. Бархүү нь бие бүрэлдэхүүнтэй гурвалсан гэрээ байгуулан 130 гаруй цэргийн алба хаагчийг унадаг дугуйтай болгов. Энэхүү аяны хүрээнд ангийн нийт бие бүрэлдэхүүний дунд “Унадаг дугуйтай 30 километрийн марш”-ыг зохион байгуулсан бөгөөд 130 гаруй цэргийн алба хаагчид идэвх санаачлагчтай оролцож, Орхон аймгийн Биеийн тамир, спортын газар, аймгийн ETV, EBS телевизүүд, Мэдээллийн биржтэй хамтран ажиллаж, аймаг орон нутгийн иргэдэд сурталчлан ажиллалаа.

Хошууч Т.ЗАЯАНДАРЬ